



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 02 дугаар сарын 26  
№08 (1304)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ  
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |     |
|------|---|-----|
| 194. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                                   | 519 |
| 195. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 538 |
| 196. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай   | 539 |
| 197. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай                                       | 541 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 198. | Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 18 | 554 |
|------|--|-----------|-----|



᠑᠙᠘᠐	Түүхэн гэрээний үндсэн дээр "Mongol Fido" ҮЗ-ийн үйлчилгээний үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	᠑᠕	᠒᠒᠗
᠑᠙᠙᠗	"Mongol Fido" ҮЗ-ийн үйлчилгээний үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	᠑᠔	᠒᠐᠑
᠑᠙᠙᠙	"Mongol Fido" ҮЗ-ийн үйлчилгээний үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	᠑᠔	᠒᠔᠙
᠑᠙᠙᠙	"Mongol Fido" ҮЗ-ийн үйлчилгээний үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	᠑᠔	᠒᠔᠙
᠑᠙᠙᠙	"Mongol Fido" ҮЗ-ийн үйлчилгээний үйлчилгээний үнэмлэхүй гэрээний үндсэн дээр	᠑᠔	᠒᠑᠙

**Mongol Fido\_ 02 Hөll**

**᠑᠑᠑᠑**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/2.2 дугаар зүйлийн 10-12 дахь хэсэг:**

“10. Энэ хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

11. Энэ хуулийн 31.5 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг хойшуулшгүйгээр баривчилсан тухай мөрдөгчийн шийдвэрийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.

12. Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах, эсхүл яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг тухайн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.”

#### **2/3.1 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:**

“5. Шүүх энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт, 31.5 дугаар зүйлд заасан асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлнэ.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан асуудлыг хянан шийдвэрлэх шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу томилно.”

#### **3/5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн

Холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**4/14.10 дугаар зүйлийн 6-12 дахь хэсэг:**

“6.Мөрдөгч яллагдагчийг цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа хугацаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлнэ.

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлнэ.

8.Шүүх цагдан хорих хугацааг сунгах тухай прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө хянан хэлэлцэж, цагдан хорих хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргана.

9.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан яллагдагчийн цагдан хорих хугацааг баривчилсан өдрөөс, эсхүл яллагдагчийг цагдан хорьсон өдрөөс эхлэн прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл тоолно.

10.Шүүгч баривчилсан, цагдан хорьсон цагийг захирамждаа заана.

11.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.”

**5/17.2 дугаар зүйлийн 5-11 дэх хэсэг:**

“5.Гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрч, хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан боловч өмгөөлөгч авахаас татгалзсан яллагдагчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.Прокурор, мөрдөгч яллагдагчид энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

6.1.тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар мэдээлэл авах;



6.2.прокурорын санал болгосон эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах;

6.3.эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар өөрийн саналыг илэрхийлэх;

6.4.шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээс татгалзах.

7.Прокурор хохирогчид энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, хохирол нөхөн төлөх талаар яллагдагчийн гаргасан санал болон энэ хуулийн Наймдугаар бүлэгт заасан эрх, үүргийг тусгайлан танилцуулна.

8.Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч зарим хэргээ хүлээн зөвшөөрөөгүй бол түүнд холбогдох хэргийг бүхэлд нь ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

9.Нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэрэг хамтран үйлдсэн яллагдагч нарын зарим нь гэм буруугаа бүрэн, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн яллагдагч нарт холбогдох хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

10.Гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн хүнд холбогдох хэргийг бусад яллагдагч нарт холбогдох хэргээс тусгаарласан бол түүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж болно.

11.Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь мөрдөн шалгах ажиллагааны явцад гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн хүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлд заасныг журамлан ял оногдуулахад саад болохгүй.”

### **6/17.3 дугаар зүйлийн 5-9 дэх хэсэг:**

“5.Яллагдагчийн хүлээн зөвшөөрсөн прокурорын саналд энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах нөхцөл байдлыг тусгаж, хэрэгт хавсаргана:

5.1.эрүүгийн хариуцлагын талаар прокурорын санал танилцуулсан он, сар, өдөр, газар;

5.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

5.3.яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн талаарх мэдээлэл;

5.4.гэмт хэрэг үйлдсэн он, сар, өдөр, газар, хэргийн товч агуулга;

5.5.гэмт хэргийн үндсэн шинж;

5.6.гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, хор уршгийн шинж чанар;

5.7.яллагдагчийн хохирол нөхөн төлсөн, эсхүл хохирол нөхөн төлөхөө бодитой илэрхийлсэн байдал;

5.8.яллагдагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд харгалзан үзэх хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал;

5.9.яллагдагчийн биеийн байцаалт;

5.10.яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол түүний үйлдэл тус бүрд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ;

5.11.Эрүүгийн хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмын дагуу ял нэгтгэснээр яллагдагчийн нийт эдлэх ялын төрөл, хэмжээ;

5.12.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу хураалгах хөрөнгө, орлого.

6.Прокурор яллагдагчийн гэм буруу, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар яллагдагчийн хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулсан саналыг яллах дүгнэлтийн хавсралтад тусгаж, хэргийг 7 хоногийн дотор шүүхэд шилжүүлнэ.

7.Прокурорын яллах дүгнэлтийн хавсралтад дараах зүйлийг тусгана:

7.1.яллагдагчтай хийсэн тохиролцооны агуулга;

7.2.яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээ;

7.3.гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг яллагдагч нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн байдал;

7.4.мөрдөн шалгах ажиллагаанд гарсан зардлын тооцоо;

7.5.хэрэгт хураагдсан, битүүмжлэгдсэн хөрөнгө, эд мөрийн баримт, тэдгээрийн байгаа газар;

7.6.прокурорын яллагдагчтай хийсэн тохиролцоог батлах хүсэлт.

8.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

9.Прокуророос эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой санал, хүсэлтээ харьяалах шүүхэд гаргана.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “1 сар” гэсний дараа “хүртэл” гэж, 14.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах/,” гэсний дараа “17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар залилах/,” гэж, 15.8 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын “шийдвэрийг өөрчлөх” гэсний дараа “, хүчингүй болгох” гэж, 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “дуу-дүрсний бичлэг,” гэсний дараа “эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт,” гэж, 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хохирогч,” гэсний дараа “гэрч,” гэж, мөн хэсгийн “иргэний хариуцагч,” гэсний дараа “сэжигтэн,” гэж, 17.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “шийдвэрлэнэ.” гэсний дараа “Энэ шийдвэрт прокурор, оролцогч гомдол, эсэргүүцэл гаргахгүй.” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/14.9 дүгээр зүйл:**

#### **“14.9 дүгээр зүйл.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ**

1.Шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид дараах үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно:

1.1.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан;

1.2.шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, эсхүл сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.3.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт,





нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.4.урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй.

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно:

2.1.энэ хуулийн 31.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3-т заасан нөхцөл;

2.2.эд хөрөнгө, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа насанд хүрээгүй хүний эсрэг, эсхүл амь нас, эрүүл мэнд, бусад шалтгааны улмаас өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүй хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн;

2.3.зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцсон;

2.4.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.5.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

3.Яллагдагч өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, эсхүл түүний амь нас, эрүүл мэндэд аюул учирч болох үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа бол прокурорын гаргасан саналыг үндэслэн шүүх яллагдагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

4.Хорих ял эдэлж байгаа ялтныг яллагдагчаар татаж мөрдөн шалгах ажиллагаа явуулахад прокурорын саналыг үндэслэн шүүх түүнийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн цагдан хорих байранд шилжүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч болно.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан бол энэ хуулийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримтална.”

**2/14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл арилаагүй гэж үзвэл яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 6 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй.”

### **3/17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан шүүхийн шийдвэрт прокурор, оролцогч гагцхүү энэ хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болно.”

### **4/31.5 дугаар зүйл:**

#### **“31.5 дугаар зүйл.Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах**

1.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дараах үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно:

1.1.гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед барьсан;

1.2.гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан;

1.3.хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол хойшлуулшгүйгээр баривчилж болно:

2.1.хэн болох нь тогтоогдоогүй;

2.2.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

2.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

3.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн даруй энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно.



4.Мөрдөгч сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор баривчлах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

4.1.мөрдөгчийн шийдвэрийг баталж, шүүхэд даруй хүргүүлэх;

4.2.мөрдөгчийн шийдвэрийг үндэслэлгүй, эсхүл үргэлжлүүлэн баривчлах шаардлагагүй гэж үзвэл батлахаас татгалзаж, тэмдэглэл үйлдэх.

5.Үндэслэлгүйгээр баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

6.Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол хойшлуулшгүйгээр баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

8.Прокурор сэжигтнийг баривчилсан шийдвэрийг хүчинтэйд тооцуулах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналаа баривчлах хугацаа дуусахаас 24 цагийн өмнө шүүхэд хүргүүлнэ.

9.Шүүх энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, прокурорын саналыг үндэслэн баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэнэ.

10.Прокурор, эсхүл баривчлах байрны даргын шийдвэрээр суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд баривчлах ажиллагааны талаар сэжигтнийг суллагдсанаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргаж болно. Прокурор гомдолд холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ.

11.Шүүх энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй.

12.Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу суллагдсан хүн гомдол гаргаагүй бол холбогдох шийдвэрийг 30 хоногийн дотор харьяалах шүүхэд хүргүүлнэ.”

#### **5/31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулна.”

#### **6/31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан, эсхүл хойшлуулшгүйгээр баривчилсан тохиолдолд энэ хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолох бөгөөд сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлшгүй эмнэлгийн тусалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг энэ хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд оруулан тооцохгүй. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах хугацаа 1 цагаас илүүгүй байна.”

**4 дүгээр зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31.8 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “шүүхийн зөвшөөрөлгүй” гэснийг “хойшлуулшгүйгээр” гэж, 31.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн зөвшөөрөлгүй” гэснийг “Хойшлуулшгүйгээр” гэж, 26.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “20.7” гэснийг “20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг” гэж, “20.8” гэснийг “20.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэж, “20.10” гэснийг “20.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “14.5 /Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх/, 14.6 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх/, 14.7 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах/, 14.8 /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/,” гэснийг, 26.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг/Хулгайлах/, 17.12 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг/Мал хулгайлах/,” гэснийг, мөн хэсгийн “20.9/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших/,” гэснийг, мөн хэсгийн “дугаар зүйл” гэснийг тус тус хассугай.

### Мадрыя Фолі\_ на Холі

Мінскага ўніверсітэта імя  
 Тарашкевіча

2018 г. 15 кастрычніка

Наадрасавана: Г-н Дзмітрый Аляксандравіч  
 Кавалевіч

Паважаны Дзмітрый Аляксандравіч, добры дзень!

Дзякуй за вашы лісты і ўвагу.

На жаль, я не магу сапраўды адказаць на вашы лісты, бо яны пераважна адносяцца да пытанняў, якіх у нас няма ў выкладчыцкім складзе, і якіх не будзе ў будучым, і якіх я не бачыў ні ў вашым лісце, ні ў нашым дыскусійным форуме. Кожны з нас павінен сапраўды адказаць на гэтыя пытанні ў сваёй спецыяльнай галіне, і гэты адказ павінен быць перададзены ў спецыяльнай форме. Мы можам даць вам дадатковыя тлумачэнні ў гэтых пытаннях, якія прыносяць вам неяснасці, асабліва ў тым, што тычыцца нашых дасягненняў і перспектываў.

У нашым дыскусійным форуме ўжо былі пачынены дыскусіі па гэтым пытанню, і я думаю, што гэта будзе пераважна аднаго характару дыскусія і не будзе адрознівацца ад іншых. Мы можам даць вам дадатковыя тлумачэнні ў гэтых пытаннях, якія прыносяць вам неяснасці, асабліва ў тым, што тычыцца нашых дасягненняў і перспектываў.

Кожны з нас павінен сапраўды адказаць на гэтыя пытанні ў сваёй спецыяльнай галіне, і гэты адказ павінен быць перададзены ў спецыяльнай форме. Мы можам даць вам дадатковыя тлумачэнні ў гэтых пытаннях, якія прыносяць вам неяснасці, асабліва ў тым, што тычыцца нашых дасягненняў і перспектываў.

С падзякай і надзеяй на далейшае супрацоўніцтва.

Наадрасавана: Г-н Дзмітрый Аляксандравіч Кавалевіч  
 Мінскага ўніверсітэта імя Тарашкевіча  
 Мінск

На жаль, я не магу сапраўды адказаць на вашы лісты, бо яны пераважна адносяцца да пытанняў, якіх у нас няма ў выкладчыцкім складзе, і якіх не будзе ў будучым, і якіх я не бачыў ні ў вашым лісце, ні ў нашым дыскусійным форуме.



















0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

0.6.0. . . . .

0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .  
0.6.0. . . . .

6.03/6 ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :

6.01. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :  
 «6.01. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :»

6.03/6 ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :

6.01. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :  
 «6.01. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :»

6.02. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :  
 «6.02. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :»

6.03. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :  
 «6.03. ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :»

ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :

ڪهڙن ڪتابن ۾ 6 ڪرد لڳيا :



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУУЛЬ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Г.ЗАНДАНШАТАР

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 176<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### **“176<sup>1</sup> дүгээр зүйл. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих**

176<sup>1</sup>.1. Шийдвэр гүйцэтгэгч хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.

176<sup>1</sup>.2. Шийдвэр гүйцэтгэгч яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

176<sup>1</sup>.3. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээнд хяналтын тоног төхөөрөмж ашиглан хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

**2 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.3 дахь заалтын “цагдан хорих” гэсний дараа “, хязгаарлалт тогтоох” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР







## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар<sup>1</sup> бүлэг нэмсүгэй:

#### “ДОЛДУГААР<sup>1</sup> БҮЛЭГ

#### Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

#### 75<sup>1</sup> дүгээр зүйл.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг

75<sup>1</sup>.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.1.1.бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;

75<sup>1</sup>.1.2.дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;

75<sup>1</sup>.1.3.хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;

75<sup>1</sup>.1.4.бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

75<sup>1</sup>.2.Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

75<sup>1</sup>.2.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;

75<sup>1</sup>.2.2.энэ хуулийн 75<sup>1</sup>.1.1-д заасан гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;

75<sup>1</sup>.2.3.ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

75<sup>1</sup>.3.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75<sup>1.4</sup>.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

75<sup>1.5</sup>.Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

### **75<sup>2</sup> дугаар зүйл.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх зарчим, хугацаа**

75<sup>2.1</sup>.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэнэ.

75<sup>2.2</sup>.Зохигч шүүх хуралдаанаас өмнө, энэ бүлэгт заасан хугацааны дотор өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

75<sup>2.3</sup>.Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75<sup>2.4</sup>.Энэ хуулийн 75<sup>2.3</sup>-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

### **75<sup>3</sup> дугаар зүйл.Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах**

75<sup>3.1</sup>.Шүүгч энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага хангагдсан бөгөөд энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75<sup>3.2</sup>.Энэ хуулийн 75<sup>4</sup> дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75<sup>4.4</sup>-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75<sup>3.3</sup>.Нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

### **75<sup>4</sup> дүгээр зүйл. Мэдэгдэх хуудсыг хүргүүлэх**

75<sup>4</sup>.1. Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаарыг, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75<sup>4</sup>.2. Энэ хуулийн 75<sup>4</sup>.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75<sup>4</sup>.3. Энэ хуулийн 75<sup>4</sup>.2-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75<sup>4</sup>.4. Энэ хуулийн 75<sup>4</sup>.2, 75<sup>4</sup>.3-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

### **75<sup>5</sup> дугаар зүйл. Хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлэх, гуравдагч этгээд оролцох**

75<sup>5</sup>.1. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэгтгэх, тусгаарлах, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, хамтран нэхэмжлэгч, хамтран хариуцагч татан оролцуулах ажиллагаа хийгдэхгүй.

75<sup>5</sup>.2. Хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш 7 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75<sup>5</sup>.3. Сөрөг нэхэмжлэл энэ хуулийн 73, 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

75<sup>5</sup>.4.Зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.

75<sup>5</sup>.5.Нэхэмжлэгч иргэний хэрэг үүсгэснээс хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасан шаардлага, үндсэн нэхэмжлэлд заасан үндэслэлийн хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа нэг удаа нэмэгдүүлж болно. Нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг хэргийн оролцогчид мэдэгдэнэ.

75<sup>5</sup>.6.Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

#### **75<sup>6</sup> дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг**

75<sup>6</sup>.1.Гэрч энэ хуулийн 43.3-т заасан эрх, үүргийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн, нотариатаар гэрчлүүлсэн мэдүүлгийг шүүхэд ирүүлсэн нь хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлгийг хангалттай гэж шүүх үзвэл нотлох баримтаар үнэлж болно.

75<sup>6</sup>.3.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлсэн нь гэрчийн мэдүүлгийг энэ хуулийн 75<sup>6</sup>.2-т заасны дагуу үнэлэхэд саад болохгүй.

#### **75<sup>7</sup> дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх**

75<sup>7</sup>.1.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш дараах нөхцөл байдал тогтоогдвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ:

75<sup>7</sup>.1.1.нэхэмжлэл гаргах, эсхүл иргэний хэрэг үүсгэхдээ энэ хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлд заасныг зөрчсөн;

75<sup>7</sup>.1.2.тухайн хэрэг нь эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.



75<sup>7.2</sup>.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.

75<sup>7.3</sup>.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

75<sup>7.4</sup>.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр үргэлжлүүлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолох үндэслэл болохгүй.

#### **75<sup>8</sup> дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх**

75<sup>8.1</sup>.Шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийн 74.1-д заасан үндэслэл бүрдвэл хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

#### **75<sup>9</sup> дүгээр зүйл.Хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр**

75<sup>9.1</sup>.Энэ хуулийн 75<sup>7.1</sup>-д зааснаас бусад тохиолдолд шүүх энэ хуулийн 75<sup>1.1</sup>, 75<sup>1.2</sup>-т заасан хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанаас шийдвэр гаргана.

75<sup>9.2</sup>.Энэ хуулийн 75<sup>9.1</sup>-д заасан шийдвэр нь удиртгал, үндэслэх, тогтоох хэсэгтэй байх бөгөөд үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, шийдвэрийн үндэслэлийн товч агуулгыг дурдана.

75<sup>9.3</sup>.Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 119 дүгээр зүйлд заасны дагуу зохигч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулна.

75<sup>9.4</sup>.Энэ хуулийн 75<sup>9.2</sup> дахь хэсэг давж заалдах шатны шүүхийн магадлалд нэгэн адил үйлчилнэ. Шийдвэр, магадлалын бүтэц, боловсруулах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

#### **75<sup>10</sup> дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр нэмэлт хугацаа тогтоох, хуваарь гарган хэсэгчлэн төлөх**

75<sup>10.1</sup>.Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн, эсхүл хэсэгчлэн хангасан бол хариуцагчийн санхүүгийн байдал, харгалзвал зохих бусад зайлшгүй шалтгаанаар, хариуцагчийн хүсэлтэд үндэслэн шийдвэрийг



биелүүлэх нэмэлт хугацаа тогтоох, эсхүл хуваарийн дагуу хэсэгчлэн төлөхөөр шүүхийн шийдвэрт зааж болно. Нэмэлт хугацаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш зургаан сараас илүүгүй байна.

**75<sup>11</sup> дүгээр зүйл.Давж заалдах гомдол гаргах**

75<sup>11</sup>.1.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75<sup>9</sup>.3-т заасны дагуу гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75<sup>11</sup>.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Мэдэгдэл № 02

Төрийн мэдээлэл

2024 оны 08 сарын 08 - 09 өдөр

Урьдчилсан гэрээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл үйлчилгээний үйлчилгээний үндсэн дээр төрийн мэдээлэл





Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:

Հ.Զ. Կենտրոնը հետևում է ՀՀ-ի տնտեսական և սոցիալական զարգացմանը և ՀՀ-ի քաղաքացիական ընտանիքի արժեքներին:









## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

### Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах асуудлыг судлан холбогдох хуулийн төслийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн боловсруулж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох зохицуулалтыг тусгах;

2/хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

3/шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулдаг үндэслэл, нөхцөл боломжийг бий болгож байгаа хуулийн хийдлийг судалж, түүнийг арилгах, зохицуулалтыг боловсронгуй болгох;

4/олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон зохицуулалтыг хуульд тусгах;

5/хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох;

6/төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан зохицуулах;



7/шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох журмыг боловсронгуй болгох;

8/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг бий болгох, 6-аас дээш сар хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

9/Өмгөөллийн тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмж тусгах;

10/сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах зохицуулалтыг боловсронгуй болгох;

11/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг сайжруулах, хэргийн оролцогчийн эрхийг хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатанд хэргийг шилжүүлдэг зохицуулалтыг тусгах;

12/мөрдөгч, прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг шүүхэд гаргах эрхийг хуульд тусгах;

13/хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолыг гардуулан өгөх зохицуулалтыг хуульд тусгах;

14/шүүх, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах асуудлыг хуульчлах.

2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хорооноос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн тогтолцоог бүрдүүлэх талаар судалж





Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

### Mongolian Folio on Yakti Horgha and Doodlegda

Монгол Улсын  
Төрийн Мэдээгэй

№ 08/1304/

2024 он 08 сарын 08 - 09

Монгол Улсын  
Төрийн Мэдээгэй

Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй

Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй

Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй

Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй

Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй

Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй  
Монгол Улсын Төрийн Мэдээгэй







**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2.75

**Индекс:** 200003